




МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



АЖ ҮЙЛДВЭР 2016

Улаанбаатар хот

2017 он



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

**АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР
2016**

**Улаанбаатар хот
2017 он**

АГУУЛГА

Хүснэгт, зургийн жагсаалт	3
Ойлголт, тодорхойлолт	5
Хамрах хүрээ	7
Оршил	8
1. Монгол улсын эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь	9
2. Уул уурхайн олборлох аж үйлдвэр	12
2.1. Нүүрс олборлолт	14
2.2. Газрын тос олборлолт	16
2.3. Алт олборлолт	17
2.4. Бусад ашигт малтмал олборлолт	18
3. Боловсруулах аж үйлдвэр	18
3.1. Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	20
3.2. Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	23
3.3. Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл	24
3.4. Арьс ширний үйлдвэрлэл	24
3.5. Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл	25
4. Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	25
4.1. Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл	25
4.2. Дулааны эрчим хүч үйлдвэрлэл	29
4.3. Түлш эрчим хүч үйлдвэрлэл	30
4.4. Ус хангамж бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31
5. Дүгнэлт	32

ХАВСРАЛТ

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧДЫН ТОО, дэд салбараар, мянган хүн

ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ТҮВШИН, салбараар, зэрэгцүүлэх үнээр, мянган төгрөгөөр

ХҮСНЭГТ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар, тэрбум төгрөг

ХҮСНЭГТ 4. УУЛ УУРХАЙ ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар, тэрбум төгрөг

ХҮСНЭГТ 5. НҮҮРС ОЛБОРЛОЛТЫН ТЭНЦЭЛ, мянган тонн'

ХҮСНЭГТ 6. НҮҮРС ОЛБОРЛОЛТЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 7. УУЛ УУРХАЙ ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН ЗАРИМ ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, мянган тонн

ХҮСНЭГТ 8. БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН БҮТЭЦ, дэд салбараар, хувиар

ХҮСНЭГТ 9. НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр

ХҮСНЭГТ 10. АРС ШИРЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр

ХҮСНЭГТ 11. ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр

ХҮСНЭГТ 12. ЦАХИЛГААН ЭЧИМ ХҮЧНИЙ ТЭНЦЭЛ, сая киловатт цаг

ХҮСНЭГТ 13. ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 14. ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТЭНЦЭЛ, мянган гигакалори

ХҮСНЭГТ 15. ҮЙЛДВЭРЛЭСЭН ЭРЧИМ ХҮЧ, жишмэл түлшинд шилжүүлснээр, мянган төгрөг

ЗУРАГ 1. ДНБ-д АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

ЗУРАГ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, дэд салбараар, хувиар

ЗУРАГ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбар, хувиар

ЗУРАГ 4. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОЛОН ГАДААД БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөг

ЗУРАГ 5. АЖ ҮЙЛДВЭР, УУЛ УУРХАЙ ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, тэрбум төгрөг

ЗУРАГ 6. НҮҮРСНИЙ ОЛБОРЛОЛТ, экспорт, сая тонн

ЗУРАГ 7. ХҮРЭН, ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОЛБОРЛОЛТ, сая тонн

ЗУРАГ 8. ГАЗРЫН ТОС ОЛБОРЛОЛТ, мянган баррель

ЗУРАГ 9. АЛТ ОЛБОРЛОЛТ, тонн

ЗУРАГ 10. АЖ ҮЙЛДВЭР, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛТИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөг

ЗУРАГ 11. МАЛЫН МАХ, МАХАН НӨӨШ, ХИАМАН ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, тонн

ЗУРАГ 12. СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, импорт, сая литр

ЗУРАГ 13. ГУРИЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, импорт, мянган тонн

ЗУРАГ 14. АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДАА, ЦЭВЭР УС, АМТАТ УС, УНДАА, ЖҮҮС, ҮЙЛДВЭРЛЭЛ, сая литр

ЗУРАГ 15. ЦЕМЕНТ, ШОХОЙ, БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭЛ

ЗУРАГ 16. ХУВАНЦАР ХҮРЭЭТЭЙ ХААЛГА, ЦОНХ, УЛААН ТООСГО, ХҮРМЭН БЛОК ҮЙЛДВЭРЛЭЛ

ЗУРАГ 17. ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ БҮТЭЦ, салбараар, хувиар

ЗУРАГ 18. ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭЛ, хэрэглээ, импорт, сая киловатт цаг

ЗУРАГ 19. НЭГ ХҮНД НОГДОХ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ, сая киловатт цаг

ЗУРАГ 20. ДУЛААНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ БҮТЭЦ, 2016 он

ЗУРАГ 21. ҮЙЛДВЭРЛЭСЭН ЭРЧИМ ХҮЧ, жишмэл түлшинд шилжүүлсэнээр, хувиар

ЗУРАГ 22. УС ХАНГАМЖ, БОХИР УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, тэрбум төгрөг

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүн гэж үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бараа, үйлчилгээг хэлнэ.

Нийт үйлдвэрлэл (тухайн оны үнээр) тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийт дүнг хэлнэ.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн гэж тайлант хугацаанд үйлдвэрлэсэн салбарын үйлдвэрлэлийг төлөөлөхүйц бүтээгдэхүүнийг хэлнэ.

Бүтээгдэхүүний борлуулалт гэж тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ.

Аж үйлдвэрийн борлуулалт гэж зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй.

Нэмэгдэл өртөг гэж нийт гаргалтаас завсрын хэрэглээг хассан дүнг хэлнэ. Нийт үйлдвэрлэлийг үндсэн үнээр, завсрын хэрэглээг худалдан авагчийн үнээр үнэлнэ.

Завсрын хэрэглээ гэж үйлдвэрлэл, үйлчилгээний явцад орц болж зарцуулагдсан бүтээгдэхүүний зардал (худалдан авсан барааны өртгөөс жилийн эцсийн нөөцийн өөрчлөлтийг хасна) болон үйлчилгээний төлбөрийг хэлнэ.

Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (дуусаагүй үйлдвэрлэл) гэж зах зээлд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй бэлэн бус бүтээгдэхүүнийг хэлнэ.

Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Ажил эрхлэлттэй холбоотой ойлголт, тодорхойлолт нь хөдөлмөрийн статистикт ашигладаг ойлголт, тодорхойлолттой адил байна.

Ажилласан цаг гэж ажиллагчид (цалин хөлстэй ажиллагч болон цалин хөлсгүй ажиллагч)-ийн ажилласан цагийг хэлнэ.

Үндсэн үнэд аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татварыг оруулж тооцохгүй ба татаасыг оруулж тооцно.

Үйлдвэрлэгчийн үнэ нь үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг бараа, үйлчилгээний татвар (нэмэгдсэн өртгийн татвараас бусад)

болон тээвэр, худалдааны нэмэгдлүүдийг нэмж, татаасыг хасч тооцсон үнийг хэлнэ.

Зах зээлийн үнэ буюу худалдан авагчийн үнэ нь үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдэл өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг хэлнэ.

Үйлдвэрлэлийн индекс гэж үнийн өөрчлөлтийн нөлөөллийг арилгасан биет хэмжээний өөрчлөлтийг илэрхийлэх индексийг хэлнэ.

Үйлдвэрлэгчийн үнийн индекс гэж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн (үйлдвэрлэгчийн үнээрх) өөрчлөлтийг илэрхийлэх индексийг хэлнэ.

Улирлын нөлөөллийг арилгах гэдэг нь хугацааны цуваан дахь улирлын шинж чанартай нөлөөллийг арилгах статистик арга юм.

Богино хугацааны үзүүлэлтэд сар, улирлын давтамжаар тооцогдож буй үзүүлэлтийг хамруулна.

ХАМРАХ ХҮРЭЭ

Аж үйлдвэрийн салбарт эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 3.1)-ын дагуу уул уурхай, олборлох аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн гэсэн гурван дэд салбарыг хамруулан авч үздэг. Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцохдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг үндсэн буюу үйлдвэрлэгчийн үнээр тооцдог бөгөөд бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлтийг мөн үнэлж тусгадаг. Нийт үйлдвэрлэлээс бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан зардлын хэмжээг хасч, тайлант хугацаанд шинээр бий болсон нэмэгдэл өртгийн хэмжээг дэд салбаруудаар тооцож байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцох мэдээллийн эх үүсвэр нь бизнес регистрийн санд бүртгэлтэй аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тайлан болон холбогдох захиргааны статистик мэдээлэл болно. Мэдээллийг сарын болон жилийн давтамжтайгаар авч доорх үзүүлэлтүүдийг тооцдог.

Сарын давтамжтайгаар: *“Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сарын мэдээ”* маягтаар үйлдвэрийн газрын тухайн сарын болон оны өссөн дүнгийн мэдээллийг биет хэмжээ, үнийн дүнгийн мэдээллээр цуглуулан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг оны үнээр; бүтээгдэхүүний нийт борлуулалт, үүнээс гадаад, дотоодын борлуулалт, нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний тухайн сард борлогдоогүй үлдэгдэл, ажиллагчдын тоо, үүнээс ажилчдын тоо, зэрэг үзүүлэлтийг тооцдог.

Жилийн давтамжтайгаар: *“Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ”*, *“Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны хураангуй мэдээ”* гэсэн маягтуудаар тухайн жилийн эхний болон эцсийн үлдэгдэл, орлого, худалдан авсан барааг дахин борлуулснаас олсон орлого, үйлдвэрлэлд зарцуулсан түүхий эд, материал, үйлдвэрлэлийн бусад зардал, ажиллагчдын цалин, татвар, татаас зэрэг орлого, зарлагын дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан нийт гаргалт, завсрын хэрэглээ, аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийг тооцож байна.

“Цахилгаан эрчим хүчний тэнцэл”, “Дулааны эрчим хүчний тэнцэл” маягтаар цахилгаан, дулааны станцуудаас мэдээлэл цуглуулдаг бөгөөд үйлдвэрлэсэн болон импортоор авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ, цахилгаан станцын дотоод хэрэглээ, түгээлтийн болон шугамын алдагдал, хуваарилалт зэрэг үзүүлэлтээр цахилгаан, дулааны эрчим хүч тэнцлийг байгуулдаг. Харин “Олборлосон нүүрсний тэнцэл” маягтын дагуу нүүрс олборлолтын мэдээг нүүрсний уурхайгаас авч, нүүрсний тэнцлийг байгуулан олборлосон нүүрсний хэмжээ, экспорт, тээвэрлэх, хадгалах үеийн хорогдол, хэрэглээг биет хэмжээгээр тооцож байна.

Оршил

Аливаа улс орны хөгжлийн гол түлхүүр нь аж үйлдвэрийн хөгжил байдаг. Аж үйлдвэрийн салбар нь төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэсэн, өндөр бүтээмжтэй дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, өрсөлдөх чадвар бүхий экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах Монгол улсын хөгжлийн тэргүүлэх салбар юм.


Манай улсын аж үйлдвэрийн салбарт 400 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаас зэсийн баяжмал, газрын тос, алт, нүүрс, төмрийн хүдэр, молибдений баяжмал, цайрын баяжмал, шар айраг, архи, гурил, амтат ус, ундаа, самнасан ноолуур, тамхи, жүүс, шингэн сүү, сүлжмэл эдлэл, металл цувимал, талх, нарийн боов, цахилгаан эрчим хүч, дулаан, түгээсэн цэвэр ус зэрэг гол нэр төрлийн 20 гаруй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нийт үйлдвэрлэлтэд 90 гаруй хувийг эзэлж байна. Эдгээр гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ цаашид нэмэгдэх хандлагатай.

Сүүлийн жилүүдэд төр, засгаас үйлдвэржилтийг дэмжсэн бодлого, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн үүний үр дүнд боловсруулах салбарт эмчилгээний цай, аяны уутан хөнжил, даавуун, савхин, цаасан уут, тор, нэхий нуруувч, нэхий гутал, бэлхэнз, амны хаалт (маск), баяжмалын даавуун шүүлтүүр, стикер, даавуун хэвлэл, шахмал түлш, эмнэлгийн боолтын материал, тосон түрхлэг, эмнэлэгийн зориулалттай спирт, гар нүүрийн саван, аяга, таваг угаагч, лед гэрэл, ванн, угаалтуур, барилгын шавардлагын зориулалттай хар замаск, плитаны цавуу, бетон зуурмагийн уян налархайжуулагч, сэндвичэн хавтан, хөнгөн цагаан эдлэл, барилгын дээврийн хавтан төмөр, цахилгаан дамжуулагч уртасгагч залгуур, айпад, өнгөт телевизор гэх мэт бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж эхэллээ.

1. Монгол улсын эдийн засагт аж үйлдвэрийн салбарын ЭЗЛЭХ ХУВЬ

Аж үйлдвэрийн салбар нь манай улсын эдийн засгийн хөгжилд голлох байр суурь эзэлдэг салбар юм. Манай улсад 2016 оны байдлаар 141.5 мянган аж ахуйн нэгж, байгууллага байгаагийн 8.5 хувь нь аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа эрхэлдэг хэдий ч дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж буй хувийн жин нь харьцангуй өндөр байгаа юм. Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 28.9 хувийг, 15 ба түүнээс дээш насны нийт ажиллагчдын 12.8 хувийг тус салбар эзэлж байна.

ЗУРАГ 1. ДНБ-д АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



*Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарт 2016 оны гүйцэтгэлээр (оны үнээр) 16718.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсний 58.9 хувийг уул уурхай олборлох аж үйлдвэр, 32.4 хувийг боловсруулах аж үйлдвэр, 7.1 хувийг цахилгаан хий уур агааржуулалт, 1.7 хувийг ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны дэд салбаруудад тус тус үйлдвэрлэсэн байна.

ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ
АЖИЛЛАГЧДЫН ТОО, дэд салбараар, мянган хүн

Салбар	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
Бүгд	1 024.1	1 041.7	1 006.3	1 033.7	1 037.7	1 056.4	1 103.6	1 110.7	1 151.2	1 147.8
АҮ-ийн салбар	123.1	124.1	113.1	119.1	127.9	132.8	153	149.1	145.4	146.5
Уул уурхай, олборлолт	44.1	46.5	34.8	34.1	45.1	46.7	50.3	41.0	42.6	38.2
Боловсруулах үйлдвэрлэл	47.9	47.5	62.7	64.8	65.8	64.9	81.0	85.5	81.3	86.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	31.1	30.1	9.5	12.4	11.9	14.5	13.8	15.5	15.6	16.2
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	-	-	6.1	7.8	5.1	6.7	7.9	7.1	5.9	6.0

*Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарт 2016 онд 146.5 мянган ажиллагчид ажиллаж байгаагийн 86.1 мянга нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 38.2 мянга нь уул уурхай олборлох үйлдвэрийн салбарт, 16.2 мянга нь цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарт, 6.0 мянга нь усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт тус тус ажиллаж байна.


ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ТҮВШИН, салбараар, зэрэгцүүлэх үнээр, мянган төгрөгөөр

Салбар	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
	2005 оны зэрэгцүүлэх үнээр			2010 оны зэрэгцүүлэх үнээр						
Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин - улсын түвшинд	26 580.0	26 362.4	37 088.5	31 234.0	84 296.6	83 936.9	88 887.6	115 287.8	125 408.8	135 907.0
Уул уурхай, олборлолт	15 506.8	14 465.6	20 445.4	31 617.9	50 173.7	52 509.0	57 769.8	84 824.8	92 904.4	104 314.4
Боловсруулах үйлдвэрлэл	5 236.1	5 421.9	3 734.7	10 263.8	10 900.2	12 014.2	10 613.3	10 475.5	11 308.6	10 352.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	3 340.9	3 762.2	10 065.4	15 345.8	17 012.6	14 705.3	16 287.2	15 393.4	15 983.5	16 096.5
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2 496.2	2 712.7	2 843.0	4 006.5	6 210.1	4 708.4	4 217.3	4 594.1	5 212.3	5 143.6

*Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмжийн түвшин 2016 онд 135907.0 мянган төгрөгт хүрч, тус салбарын нийт бүтээмжийн 76.8 хувийг уул уурхайн олборлолт, 11.8 хувийг цахилгаан, хий, уур агааржуулалтын хангамж, 7.6 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 3.8 хувийг усан хангамж бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны дэд салбарууд тус тус эзэлж байна.

ЗУРАГ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, дэд салбараар, хувиар



*Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарт 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1887.1 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд үүний 77.2 хувийг уул уурхай олборлолт, 18.4 хувийг цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамж, 4.3 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн дэд салбарын хөрөнгө оруулалт эзэлж байна.

ЗУРАГ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбар, хувиар



*Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 онд 16718.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт үйлдвэрлэлийн 58.9 хувийг уул уурхай олборлолт, 32.4 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 7.1 хувийг цахилгаан хий, уур агааржуулалт, 1.7 хувийг усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны дэд салбарууд тус тус эзэлж байна.


ХҮСНЭГТ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар, тэрбум төгрөг

Салбараар	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
Нийт дүн	581.4	2877.3	3073.5	4456.1	5596.5	6224.1	6661.1	11108.0	9998.1	11067.0
Уул уурхай, олборлолт	799.9	1860.8	2025.2	3151.9	3635.2	3829.1	4047.9	7947.7	7145.5	7884.7
Боловсруулах үйлдвэрлэл	578.3	760.6	755.5	930.1	1551.7	1940.4	2090.6	2532.0	2092.2	2323.2
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	203.1	255.9	292.8	374.1	409.6	454.6	522.6	628.2	760.4	859.1
Үүнээс: Гадаад борлуулалт										
Нийт дүн	785.4	1825.6	1907.8	3062.6	3513.8	4139.8	4002.4	7668.8	6504.9	6971.4
Уул уурхай, олборлолт	536.5	1556.4	1733.6	2897.6	3059.0	3402.5	3272.9	6790.8	5934.4	6187.8
Боловсруулах үйлдвэрлэл	248.9	269.2	174.2	165.0	454.8	737.4	729.6	878.1	570.5	783.6
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

*Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт 2016 онд 11067.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт борлуулалтын 71.2 хувийг уул уурхай олборлолт, 21.0 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 7.8 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн дэд салбар эзэлж байна. Аж үйлдвэрийн салбарын гадаад борлуулалтын 88.8 хувийг уул уурхай олборлолт, 11.2 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд тус тус эзэлж байна.

ЗУРАГ 4. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОЛОН ГАДААД БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөг




2. Уул уурхай, олборлох аж үйлдвэр

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар нь аж үйлдвэрийн салбарт томоохон хувийн жин эзэлдэг чухал салбар юм. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэр төрлөөр буюу олон улсын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0-р дараах 5 дэд салбарт ангилна.

1. Нүүрс олборлолт
2. Газрын тос олборлолт
3. Металлын хүдэр олборлолт
4. Бусал ашигт малтмал олборлолт
5. Уул уурхай олборлолтын туслах бусад үйл ажиллагаа

Сүүлийн жилүүдэд уул уурхай, эрдэс баялгийн салбар хурдацтайгаар хөгжиж, Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болж байна. Стратегийн ач холбогдол бүхий томоохон ашигт малтмалын орд, газрууд эдийн засгийн эргэлтэд орсон нь уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг цаашид өсөх нөхцлийг бүрдүүлж байна.

ЗУРАГ 5. АЖ ҮЙЛДВЭР, УУЛ УУРХАЙ ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, тэрбум төгрөг



*Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2016 онд 58.9 хувь, 2015 онд 55.1 хувь, 2011 онд 64.8 хувь, 2007 онд 64.7 хувь тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 4. УУЛ УУРХАЙ ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар, тэрбум төгрөг

Салбараар	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
Уул уурхай, олборлолт	1 799.9	1 860.8	2 025.2	3 151.9	3 635.2	3 829.1	4 047.9	7 947.7	7 145.5	7 884.7
Нүүрс олборлолт	118.2	192.9	423.2	1 104.5	1 436.3	1 063.2	803.2	926.8	751.7	1 522.4
Газрын тос олборлолт	50.0	107.5	162.1	209.2	303.8	456.3	776.1	1 153.8	784.4	732.1
Металлын хүдэр олборлолт	1 593.1	1 512.0	1 399.0	1 772.6	1 821.1	2 287.0	2 410.2	5 779.2	5 543.9	5 562.3
Бусад ашигт малтмал олборлолт	38.6	48.4	40.9	65.6	74.0	22.6	58.3	87.9	65.5	68.0
Үүнээс: Гадаад борлуулалт	1 536.5	1 556.4	1 733.6	2 897.6	3 059.0	3 402.5	3 272.9	6 790.8	5 934.4	6 187.8
Нүүрс олборлолт	0 62.1	0 110.8	0 325.6	0 988.0	1 311.1	0 915.6	0 635.7	0 754.3	0 544.8	1 274.2
Газрын тос олборлолт	0 50.0	0 107.5	0 162.1	0 209.2	0 303.8	0 456.3	0 776.1	1 153.8	0 784.4	0 732.1
Металлын хүдэр олборлолт	1 392.3	1 296.3	1 210.5	1 648.5	1 383.9	2 015.7	1 826.4	4 823.5	4 558.9	4 136.4
Бусад ашигт малтмал олборлолт	0 32.0	0 41.8	0 35.4	0 52.0	0 60.1	0 15.0	0 34.6	0 59.2	0 46.3	0 45.1

*Урьдчилсан гүйцэтгэл

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт борлуулалт 2016 онд 7884.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 10.3 хувиар, 2011 оноос 2.2 дахин, 2007 оноос 4.4 дахин тус тус өссөн байна. Үүнээс гадаад борлуулалт 2016 онд 6187.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 4.3 хувиар, 2011 оноос 2 дахин, 2007 оноос 4.0 дахин өссөн байна.

2.1 Нүүрс олборлолт

Налайхын нүүрсний уурхайг анх 1922 онд сэргээж ашигласнаас хойш нүүрс олборлолтын хэмжээнд мэдэгдэхүйц ахиц гарч, 1928 онд 10.9 мянган тонн нүүрс олборлож байсан бол 1940 онд 174.1 мянган тонн, 1980 онд 4.4 сая тонн, 1990 онд 7.2 сая тонн, 2000 онд 5.2 сая тоннд хүрч, эх орныхоо нүүрсний хэрэгцээг дотооддоо хангах бүрэн бололцоотой болсон юм.

Монгол Улс нүүрсний нөөцөөр дэлхийн эхний 10 орны тоонд багтдаг. Одоогийн байдлаар 15 сав газрын хүрээнд 300 гаруй орд, илрэл байгаа бөгөөд Монгол орны нүүрсний геологийн таамаг нөөц 173.3 тэрбум төгрөг бөгөөд цаашдаа өсөх боломжтой. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт төрийн болон орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгж байгууллага 8 уурхайд, дотоодын болон хамтарсан 28 аж ахуйн нэгж байгууллага 33 уурхайд, гадаадын хөрөнгө оруулалттай 7 аж ахуйн нэгж 8 уурхайд тус тус нүүрс олборлож байна. *(Ашигт малтмал, газрын тосны газар)*

ХҮСНЭГТ 5. НҮҮРС ОЛБОРЛОЛТЫН ТЭНЦЭЛ, мянган тонн


Үзүүлэлтүүд	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
Нөөц-Бүгд	9 555.5	10 453.7	14 883.5	26 506.1	34 903.9	38 809.4	38 981.5	33 413.4	30 373.6	42 140.4
Эхний үлдэгдэл	317.3	381.3	441.2	1 344.0	2 874.1	8 883.0	8 857.5	8 124.2	6 166.9	6 617.6
Үйлдвэрлэсэн	9 237.6	10 071.9	14 442.1	25 161.9	32 029.7	29 926.1	30 123.3	25 287.8	24 205.9	35 522.3
Төрийн өмчит уурхай	6 259.7	6 674.2	7 186.7	10 459.5	12 090.3	10 335.6	12 322.2	11 087.5	10 281.3	18 711.0
Хувийн хэвшлийн уурхай	2 977.9	3 397.7	7 255.4	14 702.4	19 939.4	19 590.5	17 801.1	14 200.3	13 924.6	16 811.3
Импорт	0.6	0.5	0.2	0.2	0.1	0.3	0.7	1.4	0.8	0.5
Хэрэглэсэн-Бүгд	5 906.1	5 843.2	6 426.2	6 905.8	6 815.3	7 381.3	8 180.9	8 342.2	7 793.3	8 598.6
ДЦС-д хэрэглэсэн	4 935.1	4 849.9	5 077.9	5 533.2	5 410.1	5 800.9	6 374.7	6 650.9	6 687.5	6 727.3
ААНБ болон өрхөд түлшний зориултаар нийлүүлсэн	971.0	993.3	1 348.3	1 372.6	1 405.2	1 580.4	1 806.2	1 691.3	1 105.8	1 871.3
Аж үйлдвэр, барилга	203.0	190.1	226.3	179.6	221.9	336.6	222.7	144.0	53.3	152.4
Тээвэр, холбоо	121.7	41.3	41.2	49.5	52.5	42.2	11.3	49.9	45.1	47.5
Хөдөө аж ахуй	3.4	7.2	13.6	10.0	8.9	3.7	7.5	8.1	7.8	6.0
Орон сууц, нийтийн аж ахуй	454.8	580.6	598.2	614.9	641.3	637.0	787.5	568.4	510.5	748.3
Үүнээс: өрхөд	375.2	406.6	596.5	612.3	639.7	626.0	783.2	563.6	508.6	744.9
Бусад	188.1	174.1	469.0	518.6	427.5	480.8	615.1	532.4	337.3	702.7
Дахин боловсруулах үйлдвэрт	-	-	-	-	2 578.1	7 047.1	10 082.9	4 590.2	2 614.4	3 030.4
Экспорт	3 268.1	4 169.3	7 113.2	16 726.2	16 627.5	15 523.5	12 593.5	14 314.1	13 348.3	24 107.3
Тээвэрлэх, хадгалах үеийн хоргодол	-	-	-	-	53.1	80.1	162.1	338.5	151.8	214.3
Эцсийн үлдэгдэл	381.3	441.2	1 344.0	2 874.1	8 883.0	8 857.5	8 124.2	6 166.9	6 617.6	6 404.2

*Урьдчилсан гүйцэтгэл

2016 онд 35.5 сая тонн нүүрс олборлосон нь 2015 оноос 11.3 сая тонн буюу 46.7 хувиар, 2011 оноос 3.5 сая тонн буюу 10.9 хувиар, 2007 оноос 26.3 сая тонн буюу 3.9 дахин тус тус өссөн байна. Нийт хэрэглэсэн нүүрсний 6.7 сая тонн буюу 78.2

хувь нь 2016 онд дулааны цахилгаан станцуудад, 1.9 сая тонн буюу 21.8 хувь нь эдийн засгийн салбарууд болон өрхөд ногдож байна (Хүснэгт 5).

ЗУРАГ 6. НҮҮРСНИЙ ОЛБОРЛОЛТ, экспорт, сая тонн



*Урьдчилсан гүйцэтгэл

Нүүрсний экспортын хэмжээ 2016 онд 24.1 сая тоннд хүрч, 2015 оноос 10.8 сая тонн буюу 81.2 хувиар, 2011 оноос 7.5 сая тонн буюу 45.2 хувиар, 2007 оноос 20.8 сая тонн буюу 7.3 дахин өсөж нүүрс нь экспортын тэргүүлэгч бүтээгдэхүүн болсон. Нүүрсний 2016 оны нийт нөөцийн 24.1 сая тонн буюу 57.2 хувийг БНХАУ-д экспортолсон байна.

ХҮСНЭГТ 6. НҮҮРС ОЛБОРЛОЛТЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
АУ-ийн нийт үйлдвэрлэл, оны үнээр, тэрбум төгрөг	3 197.0	3 461.3	3 594.5	4 987.0	8 777.3	9 821.3	10 443.7	14 402.9	14 803.2	16 718.3
Уул уурхай, олборлолт	2 066.9	2 034.4	2 294.7	3 097.0	5 686.3	5 787.0	6 099.8	9 271.3	8 154.6	9 843.4
Нүүрс олборлолт	147.5	203.2	482.5	926.8	2 145.6	1 722.6	1 461.1	1 081.7	952.5	1 690.5
Дүнд эзлэх хувь:										
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	64.7	58.8	63.8	62.1	64.8	58.9	58.4	64.4	55.1	58.9
Нүүрс олборлолтын дэд салбар	4.6	5.9	13.4	18.6	24.4	17.5	14.0	7.5	6.4	10.1
Олборлосон 1 тонн нүүрсний өртөг, мянган төгрөг	13.0	17.6	28.9	33.9	40.3	44.5	36.4	34.5	32.1	38.5


*Урьдчилсан гүйцэтгэл

Нүүрс олборлолтын дэд салбарт 2016 онд 1690.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 оноос 738.0 тэрбум төгрөг буюу 77.5 хувиар, 2007 оноос 1543.0 төгрөг буюу 11.5 дахин өсөж, 2011 оноос 455.1 тэрбум төгрөг буюу 21.2 хувиар буурчээ.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтэд нүүрс олборлолтын эзлэх хувийн жин 2016 онд 10.1 хувь болж, 2007 оноос 5.5 пункт, 2015 оноос 3.0 пунктээр

нэмэгдэж, 2011 оноос 14.3 пунктээр буурсан байна. Нүүрсний өртгийн үзүүлэлтийг авч үзвэл 1 тонн нүүрсний өртөг 2007 онд 13037.3 төгрөг байсан бол 2016 онд 38492.2 төгрөгт хүрч 3.0 дахин өссөн байна (Хүснэгт 6).

ЗУРАГ 7. ХҮРЭН, ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОЛБОРЛОЛТ, сая тонн




*Урьдчилсан гүйцэтгэл

Олборлосон нүүрсийг “Бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсын нэгдсэн ангилал”-ын дагуу хүрэн ба чулуун нүүрс гэж ангилдаг бөгөөд 2016 онд олборлосон нийт нүүрсний 28.9 сая тонн буюу 81.4 хувь нь чулуун нүүрс, 6.7 сая тонн буюу 18.6 хувь нь хүрэн нүүрс байна. Чулуун нүүрсийг “Таван толгой”, “Энержи ресурс”, “Монгол алт” корпораци гэх мэт Өмнөговь аймагт олборлолт хийдэг томоохон аж ахуйн нэгжүүд, харин хүрэн нүүрсийг Багануур, Шивээ-Овоо гэх мэт аж ахуйн нэгжүүд олборлож байна.

2.2 Газрын тос олборлолт

Манай улс 1998 оноос газрын тос олборлож, газрын тосны олборлох салбар шинээр хөгжиж ирсэн. 2016 онд 8249.8 мянган баррель газрын тос олборлосон нь 2015 оноос 519.5 мянган баррель буюу 5.9 хувиар буурж, 2011 оноос 5700.9 мянган баррель буюу 3.2 дахин, 2007 оноос 7416.6 мянган баррель буюу 9.9 дахин тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ 8. ГАЗРЫН ТОС ОЛБОРЛОЛТ, мянган баррель




*Урьдчилсан гүйцэтгэл

2.3 Алт олборлолт

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль 2009 онд батлагдан, хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор алтны үйлдвэрлэлийн хэмжээ харьцангуй буурч байсан билээ. Засгийн газраас алтны олборлолтыг дэмжиж хууль эрхзүй, татварын таатай нөхцөл бүрдүүлснээр 2013 оноос үйлдвэрлэл өссөн. Цаашид ч алт олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай хэмээн үзэж, 2016 онд Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монгол банкны хамтарсан ажлын хэсэг байгуулагдан, “Алт-2” хөтөлбөрийг боловсруулж, 2017 оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна. *(Ашигт малтмал, газрын тосны газар)*

Алт олборлолт 2016 онд 18.4 тонн болж, өмнөх оноос 3.9 тонн буюу 26.9 хувиар, 2011 оноос 12.9 тонн буюу 3.3 дахин, 2007 оноос 1.3 тонн буюу 7.6 хувиар өссөн байна.

ЗУРАГ 9. АЛТ ОЛБОРЛОЛТ, тонн



2.4 Бусад ашигт малтмал олборлолт

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзвэл 2016 онд зэсийн баяжмал, төмрийн хүдэр болон төмрийн хүдрийн баяжмал өмнөх онтой харьцуулахад өсөж, харин хайлуур жонш болон хайлуур жоншны баяжмал өмнөх онтой харьцуулахад буурч, молибдений баяжмал өмнөх онтой ижил хэмжээний үйлдвэрлэлтэй байна.

Зэсийн баяжмал, металл агуулгаараа 2016 онд 1445.1 мянган тонн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 110.4 мянган тонн буюу 8.3 хувиар, 2011 оноос 931.4 мянган тонн буюу 2.8 дахин, 2007 оноос 902.0 мянган тонн буюу 2.7 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 7. УУЛ УУРХАЙ ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН ЗАРИМ ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, мянган тонн

Ашигт малтмалын төрөл	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	543.1	525.3	533.1	522.0	513.7	517.9	803.0	1 080.4	1 334.7	1 445.1
Молибдений баяжмал, металл агуулгаараа	4.0	3.8	5.3	4.4	4.0	3.9	3.7	4.1	5.2	5.2
Хайлуур жонш	637.9	545.8	628.8	727.0	658.7	484.4	161.7	303.0	183.5	167.7
Хайлуур жоншны баяжмал	131.8	142.9	115.3	140.7	116.4	157.2	76.4	71.9	47.3	34.1
Төмрийн хүдэр	265.1	1 387.4	1 379.0	3 076.6	5 193.9	6 898.0	5 011.9	6 293.1	4 273.6	4 936.2
Төмрийн хүдрийн баяжмал	-	-	-	126.6	484.4	5 214.1	6 124.0	3 967.4	1 899.8	2 209.9
Цайрын баяжмал	154.7	143.6	141.5	112.6	104.7	119.1	104.1	93.2	89.6	100.2
Гянтболдын баяжмал	0.2	0.1	0.0	0.0	0.0	0.1	-	1.0	1.0	0.7

*Урьдчилсан гүйцэтгэл

3. Боловсруулах аж үйлдвэр

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт дараах дэд салбаруудыг багтаан авч үздэг.

- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Ундааны үйлдвэрлэл
- Тамхи үйлдвэрлэл
- Нэхмэлийн үйлдвэрлэл
- Хувцас үйлдвэрлэл
- Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт
- Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа
- Кокс болон газрын тосны боловсруулсан бүтээгдэхүүний үйл ажиллагаа
- Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Эм, эм бэлдмэл, химийн болон ургамлын гаралтай эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Резинэн болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл
- Металл үйлдвэрлэл
- Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Компьютер, электроник болон хараа зүйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл
- Дээрх дэд салбарт ороогүй бусад машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэл
- Моторт авто тээврийн хэрэгсэл, чиргүүл, хагас чиргүүл үйлдвэрлэл
- Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл
- Тавилга үйлдвэрлэл
- Бусад боловсруулах үйлдвэрлэл
- Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар үйлчилгээ


ХҮСНЭГТ 8. БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН БҮТЭЦ, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	14.2	17.9	25.0	21.6	15.6	14.9	17.0	16.2	47.3	49.2
Ундааны үйлдвэрлэл	13.0	15.5	17.6	17.9	20.6	18.4	16.0	16.7	12.1	12.8
Тамхины үйлдвэрлэл	2.7	1.3	2.4	1.6	1.7	1.4	1.9	1.8	1.2	0.4
Нэхмэлийн үйлдвэрлэл	23.6	19.9	21.0	13.0	8.6	6.8	8.8	7.7	6.0	7.2
Хувцас үйлдвэрлэл	4.6	2.5	2.2	8.5	8.9	6.8	7.0	6.8	5.4	5.3
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1.4	2.3	2.8	3.2	2.9	3.2	3.0	2.3	2.1	3.5
Хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	2.4	2.7	3.5	2.3	2.4	2.9	2.3	1.7	1.4	1.4
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	5.3	7.7	7.3	8.9	9.0	12.0	10.3	9.1	5.9	5.6
Металл үйлдвэрлэл	25.9	20.8	8.4	8.7	4.8	4.0	3.9	7.7	5.7	4.0
Бусад	7.0	9.5	9.8	14.2	25.5	29.6	29.8	29.9	13.0	10.8
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

*Урьдчилсан гүйцэтгэл

Боловсруулах салбарын бүтцийг дэд салбараар авч үзвэл 2016 онд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 49.2 хувь, ундаа үйлдвэрлэл 12.8 хувь, нэхмэлийн үйлдвэрлэл 7.2 хувь, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл 5.6 хувь, бусад салбар 25.2 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 10. АЖ ҮЙЛДВЭР, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөг



Боловсруулах үйлдвэрлэлийн нийт борлуулалт 2016 онд 2323.2 тэрбум төгрөгт хүрч аж үйлдвэрийн нийт борлуулалтын 21.0 хувийг эзэлж байна. Үүнээс хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл 46.9 хувь, нэхмэлийн үйлдвэрлэл 17.1 хувь, төмрийн үйлдвэрлэл 11.3 хувь, кокс, шахмал түлш үйлдвэрлэл 8.6 хувь, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл 4.6 хувь, бусад үйлдвэрлэл 11.5 хувийг эзэлж байна.

3.1 Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл


Боловсруулах аж үйлдвэрийн салбарт хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувийн жин 2016 онд 46.9 хувь байна. Манай улс сүүлийн жилүүдэд хүнсний аюулгүй байдалд ихээхэн анхаарал хандуулж, дотоодын жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, импортыг орлохуйц хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх болсон нь тус дэд салбарын үйлдвэрлэлийн бүтэц хэвийн түвшинд байх нөхцлийг бүрдүүлсэн юм. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбар нь дараах дэд бүлгээс бүрддэг.

1. Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт
2. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
3. Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл
4. Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл
5. Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/

Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ 2016 онд 8.9 мянган тонн болж, 2015 оноос 3.7 мянган тонн буюу 29.0 хувиар, 2011 оноос 5.1 мянган тонн буюу 36.2 хувиар буурч, 2007 оноос 2.2 мянган тонн буюу 32.2 хувиар өссөн байна. Хиаман төрлийн бүтээгдэхүүн 2016 онд 4628.3 тонн болж 2015 оноос 1267.3 тонн буюу 37.7 хувиар, 2011 оноос 2466.6 тонн буюу 2.1 дахин, 2007 оноос 3305.7 тонн буюу 3.5 дахин өссөн байна.

ЗУРАГ 11. МАЛЫН МАХ, МАХАН НӨӨШ, ХИАМАН ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТОНН




*Урьдчилсан гүйцэтгэл

Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Манай улс сүү, сүүн бүтээгдэхүүний ихэнх хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Сүү үйлдвэрлэл 2016 онд 63.3 сая тонн болж, 2015 оноос 6.3 сая тонн буюу 9.1 хувиар буурч, 2011 оноос 8.3 сая тонн буюу 15.1 хувиар, 2007 оноос 53.2 сая тонн буюу 6.3 дахин өссөн байна.


ЗУРАГ 12. СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, импорт, сая литр



*Урьдчилсан гүйцэтгэл

Гурилын үйлдвэрлэл нь хүн амын өргөн хэрэглээний бүтээгдэхүүний нэг бөгөөд сүүлийн жилүүдэд гурилын хэрэгцээний ихэнх хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Гурилын үйлдвэрлэл 2016 онд 209.7 мянган тонн болж, 2015 оноос 3.2 мянган тонн буюу 1.5 хувь, 2011 оноос 108.2 мянган тонн буюу 2.1 дахин, 2007 оноос 139.4 мянган тонн буюу 3.0 дахин өсжээ.

ЗУРАГ 13. ГУРИЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, импорт, мянган тонн




*Урьдчилсан гүйцэтгэл

Ундаа үйлдвэрлэл

Ундаа үйлдвэрлэлийн бүлэгт архи, спирт, дарс, пиво, хийжүүлсэн цэвэр ус, рашаан, амтат ус, ундаа, сироп, жүүс зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. 2016 онд 8.6 сая литр спирт, 23.9 сая литр архи, дарс, 75.7 сая литр шар айраг, 59.1 сая литр цэвэр ус, 128.9 сая литр амтат ус, ундаа, 55.8 сая литр жүүс үйлдвэрлэсэн байна.

ЗУРАГ 14. АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДАА, ЦЭВЭР УС, АМТАТ УС, УНДАА, ЖҮҮС ҮЙЛДВЭРЛЭЛ, сая литр




3.2 Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт барилгын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох цемент, шохой, бетон зуурмаг, шавардлагын зуурмаг, хөнгөн бетон, вакум цонх, хаалга, хөөсөнцөр хавтан, хүрмэн блок, төмөр бетон эдлэл, металл бэлдэц, металл цувимал, улаан тоосго, замын хавтан, хашлага зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Барилгын материалын гол бүтээгдэхүүн болох цементний үйлдвэрлэл 2016 онд 432.4 мянган тонн, шохой үйлдвэрлэл 47.6 мянган тонн, бетон зуурмаг үйлдвэрлэл 75.6 мянган метр куб байна.

ЗУРАГ 15. ЦЕМЕНТ, ШОХОЙ, БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭЛ



*Урьдчилсан гүйцэтгэл

Улаан тоосгоны үйлдвэрлэл 2016 онд 20473.2 мянган ширхэг, хуванцар хүрээтэй хаалга, цонхны үйлдвэрлэл 32711.4 метр квадрат, хүрмэн блок 317.5 мянган ширхэг байна. Хуванцар хүрээтэй хаалга, цонх болон улаан тоосгоны үйлдвэрлэл 2011 оноос өндөр өсөлттэй байсан бөгөөд 2014 оноос үйлдвэрлэлийн хэмжээ буурсан байна.

ЗУРАГ 16. ХУВАНЦАР ХҮРЭЭТЭЙ ХААЛГА, ЦОНХ, УЛААН ТООСГО, ХҮРМЭН БЛОК ҮЙЛДВЭРЛЭЛ



*Урьдчилсан гүйцэтгэл

3.3 Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Монголын дотоод зах зээл багтаамж багатай хэдий ч, ноолуурын салбарын нийт бүтээгдэхүүний 60 орчим хувь нь дотоод зах зээл дээр борлогдож байна. Манай улсад ирж буй жуулчид голдуу ноолууран бүтээгдэхүүн худалдан авч байна (ХХААХҮЯ). Ноос ноолууран бүтээгдэхүүний гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох самнасан ноолуур 2016 онд 776.3 тонн болж 2015 оноос 21.8 тонн буюу 2.9 хувиар өсөж, 2011 оноос 98.0 тонн буюу 11.2 хувиар, 2007 оноос 778.4 тонн буюу 2 дахин буурсан байна.

ХҮСНЭГТ 9. НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр

Бүтээгдэхүүний төрөл	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
Самнасан ноолуур /т/	1 554.7	1 723.8	1 586.7	824.7	874.3	417.0	521.8	633.2	754.5	776.3
Угаасан ноос /мян.т/	1.7	1.8	1.3	2.3	1.8	1.1	0.9	1.4	1.8	7.0
Тэмээний ноосон ээрмэл /т/	32.8	28.1	56.4	90.2	10.0	11.6	9.9	6.7	0.4	-
Хивс /мян.м2/	658.1	856.5	542.2	609.6	850.8	915.8	852.9	743.6	680.1	439.1
Тэмээний ноосон хөнжил /мян.м/	37.7	35.0	36.9	15.3	25.8	8.2	14.7	18.5	23.0	12.2
Эсгий /мян.м/	60.1	69.0	70.2	104.5	208.0	219.4	142.0	127.9	125.6	89.4
Эсгий гутал /мян.хос/	4.5	2.5	6.4	19.2	25.2	22.1	15.2	8.0	12.0	0.5
Ноолууран сүлжмэл эдлэл /мян.ш/	667.1	514.3	613.9	731.1	757.9	795.1	932.8	954.4	829.3	812.5

*Урьдчилсан гүйцэтгэл

3.4 Арьс ширний үйлдвэрлэл

Арьс ширний үйлдвэрлэл нь хөнгөн үйлдвэрийн томоохон салбарын нэг юм. Өнөөгийн байдлаар арьс шир боловсруулах 34 үйлдвэр Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Баянгол дүүрэг, Дархан хот гэсэн 3 газар байрлаж үйл ажиллагаа явуулж байна. Үүний зэрэгцээ, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 100 гаруй жижиг дунд үйлдвэрүүд нийслэл, аймаг орон нутагт ажиллаж байна (ХХААХҮЯ).

ХҮСНЭГТ 10. АРЬС ШИРЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр

Бүтээгдэхүүний төрөл	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
Савхин гутал, ботинк хос/ /мян.	17.2	2.7	2.3	2.2	2.9	9.9	10.4	39.7	49.9	34.1
Савхин дээл /мян.ш/	1.7	2.7	3.7	5.6	5.0	8.9	5.2	7.1	6.6	10.6
Савхин цамц /мян.ш/	0.1	0.0	0.0	0.0	0.3	0.8	0.5	0.9	0.7	0.3
Нэхий дээл /мян.ш/	12.4	11.4	12.1	16.6	22.5	9.0	16.8	14.1	10.2	9.2
Шевро /мян.м2/	29.4	3.7	1.4	1.2	1.3	1.6	1.9	1.7	3.4	2.1
Улны шир /т/	0.5	1.1	1.0	0.8	0.6	1.2	1.0	0.8	21.1	6.5
Хром, Булигаар /мян.м2/	1.9	1.2	1.8	1.6	2.4	1.7	2.7	1.3	11.8	3.9

*Урьдчилсан гүйцэтгэл

Арьс ширэн бүтээгдэхүүний гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох савхин гутал, ботинк 2016 онд 34.1 мянган хос, савхин дээл 10.6 мянган ширхэг, савхин цамц 0.3 мянган ширхэг, нэхий дээл 9.2 мянган ширхэг, шевро 2.1 мянган метр квадрат, улны шир 6.5 тонн, хром булигаар 3.9 мянган метр квадрат үйлдвэрлэсэн байна.

3.4 Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл

